**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 11 өдөр Дугаар А/522 Улаанбаатар хот

Нийслэлийн хүүхдийн 213 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 10,543,700.0 (арван сая таван зуун дөчин гурван мянга долоон зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн хүүхдийн 213 дугаар цэцэрлэг (М.Нэргүй)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 1 нэр төрлийн 360,000.0 (гурван зуун жаран мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 11 нэр төрлийн 10,183,700.0 (арван сая нэг зуун наян гурван мянга долоон зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Нийслэлийн хүүхдийн 213 дугаар цэцэрлэг (М.Нэргүй)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА В.ОЮУМАА

1425031295

D. Ayurzana

Нийслэлийн өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны 11 дүгээр сарын 11 ны
өдрийн A/519 дугаар тушаалын хавсралт

# Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн хүүхдийн 213 дугаар цэцэрлэг

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | хэмжих нэгж | тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулласан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | Байгууллагын үнийн санал | НӨХГ мэргэжилтний үнийн санал | ЭБХХХК-ын хурлын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Угаалгын машин | 5 | ш | 1 | 309,900.0 | 309,900.0 | 309,900.0 | - | ашиглалтын шаардлага хангахгүй | актлах | устгах | татах | татах |
| 2 | Хөгжим /matata/ | 5 | ш | 6 | 200,000.0 | 1,200,000.0 | 1,200,000.0 | - | | актлах | устгах | татах | татах |
| 3 | Зөөврийн компьютер | 5 | ш | 1 | 2,420,000.0 | 2,420,000.0 | 2,420,000.0 | - | | актлах | 10,000.00 | татах | татах |
| 4 | Тоос сорогч sharp | 2 | ш | 1 | 124,900.0 | 124,900.0 | 124,900.0 | - | | актлах | устгах | татах | татах |
| 5 | Будаа агшаагч 23л | 5 | ш | 1 | 240,000.0 | 240,000.0 | 240,000.0 | - | | актлах | устгах | татах | татах |
| 6 | Зөөврийн комьютер Dell | 5 | ш | 2 | 1,700,000.0 | 3,400,000.0 | 3,400,000.0 | - | | актлах | 20,000.00 | татах | татах |
| 7 | Тоос сорогч DD5510-0 | 5 | ш | 1 | 309,000.0 | 309,000.0 | 309,000.0 | - | | актлах | устгах | татах | татах |
| 8 | Зөөврийн чанга яригч | 2 | ш | 1 | 48,000.0 | 48,000.0 | 48,000.0 | - | | актлах | устгах | татах | татах |
| 9 | Ширээний компьютер dell | 2 | ш | 1 | 701,900.0 | 701,900.0 | 701,900.0 | - | | актлах | устгах | татах | татах |
| 10 | Проектор /Epson/ | 5 | ш | 1 | 1,250,000.0 | 1,250,000.0 | 1,250,000.0 | - | | актлах | 5,000.00 | татах | татах |
| 11 | Өнгөт принтер I380 | 2 | ш | 1 | 180,000.0 | 180,000.0 | 180,000.0 | - | | актлах | устгах | татах | татах |
| | Машин тоног төхөөрөмжийн дүн | | | 17 | | | 10,183,700.0 | | | | | | |
| 12 | Вэйб сайт | 4 | ш | 1 | 360,000.0 | 360,000.0 | 360,000.0 | - | | актлах | устгах | устгах | устгах |
| | Биет бус хөрөнгийн дүн | | | 1 | | | 360,000.0 | | | | | | |
| | Нийт данснаас хасах хөрөнгийн дүн | | | 18 | | 10,543,700.0 | | - | - | - | 45,000.0 | - | |
| | Үнээс Худалдах хөрөнгө | | | | | | | | | | | | |
| | Актлах хөрөнгө | | | | | 360,000.0 | | | | | | | |
| | Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | 10,183,700.0 | | | | | | | |